ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ГОНЧИГДОРЖ ОВОГТОЙ ШҮРЭНЧУЛУУНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| НЭГ."ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023.05.22-ны өдрийн 01/536 тоот "Импортын гахайн мах, махан бүтээгдэхүүний судалгаа ирүүлэх"-тухай албан бичгийн дагуу Алтанбулаг, Замын-Үүд боомтуудаар импортлогдсон гахай, гахайн мах, өөхний хилээр нэвтрүүлсэн мэдээ, хийгдсэн хяналт шалгалт, лабораторийн шинжилгээнд хамрагдсан байдлыг мэдээлэл, судалгааг хүргүүлж мал, амьтны гоц халдварт өвчин /африк гахайн мялзан/ -ий тандалт судалгааны ажилд дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан.<br>МУ-д БНХАУ, ОХУ, Польш улсуудаас импортлогдсон гахайн мах, өөхнөөс халдварт өвчний үүсгэгч, сэжигтэй тохиолдол илрээгүй. | - Мал амьтны гоц халдварт өвчин үед хариу арга хэмжээг шуурхай авч ажиллана.<br><br>- Гэрийн тэжээвэр амьтан, цацрагийн дохионы бүртгэл, халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэл, түр тусгаарлалт, зорчигч, тээврийн хэрэгслийн эрүүл мэндийн хяналтыг захиргааны статистикийн бүртгэлийн мэдээнд оруулах асуудлыг судалж, мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулна. | Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах" төслийн "Хилийн хяналт удирдлагын систем"-д Гэрийн тэжээвэр амьтан, цацрагийн бүртгэл, халдваргүйжүүлэлт, шарилын бүртгэлийг хорио цээрийн модуль, түр тусгаарлалтын модуль оруулан шаардлагын тодорхойлолт боловсруулан хөгжүүлэлтийг эхлүүлж, тестийн орчинг үүсгэсэн.<br>Мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдад зориулсан хяналт шалгалт хийх зааврыг МЭ-ийн хяналтын чиглэлээр 8 төрлөөр боловсруулхаар тохирсон. Үүнээс Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн импортлох болон малын тэжээл, тэжээлийн нэмэлт импортлох үеийн хяналт шалгалтын зааврыг боловсруулан батлуулах шатандаа ажиллаж байна.<br>Улаанбаатар хотын ГГ, Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газартай хамтран 2024.05.29-ний өдөр зохион байгуулсан Малын гоц халдварт "шүлхий" өвчин, гаалийн хяналтын бүсэд гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний үзүүлэх сургалтад санал өгч оролцсон.<br>ГЕГ-ын даргын удирдамж, тушаалын дагуу Сүхбаатар аймгийн Бичигт боомтын үйл ажиллагаа хорио цээрийн хяналт | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгалт хэрхэн хийгдэж байгаатай танилцах, байгалын хадлан өвс бэлтгэх, ариутгах байгууламжийн үйл ажиллагааг шалгах ажлын хэсэгт томилогдон ажиллаж хийгдсэн хяналт, шалгалтын танилцуулгыг байгууллагын удирдлагуудад танилцуулж ажилласан. | | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/400 тоот “Ажлийн хэсэг байгуулах тухай” тушаалаар байгуулагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт томилогдон ажиллаж 2 удаагын хуралд оролцож хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал өгч ажилласан.<br>Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/226 тоот “Ажлийн хэсэг байгуулах тухай” тушаалаар МУ-аас БНХАУ-д адууны дайвар бүтээгдэхүүн экспортлох үеийн хорио цээрийн протокол байгуулахад айлын талаас хүссэн үйлдвэрлэлийн үеийн тайлан боловсруулах, БНХАУ-аас чанарын шаардлага хангаагүйн | -Улсын хилээр нэвтрүүлж буй бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагааг холбогдох гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулалтын бүтцийн бусад нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай уялдуулж ажиллана.<br>- Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд хийх хяналт, шалгалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, газар хороодыг мэргэжлийн удирдлагаар хангана. | Хэлтсийн “Дотоод ажил үүргийн хуваар”-ийн дагуу Замын-Үүд боомтын хорио цээрийн хяналт шалгалтаар илэрч саатуулсан, хураасан, устгасан, буцаасан бараа, бүтээгдэхүүний мэдээг 2024 оны 05-р сарын 25-ны байдлаар авч нэгтгэсэн.<br>Хэлтсийн “Дотоод ажил үүргийн хуваар”-ийн дагуу Хорио цээрийн хяналт шалгалтад хамрагдсан барааны мэдээг 8 дугаар сарын байдлаар Гаалийн газар хороодоос авч нэгтгэн Статистикийн газарт хүргүүлсэн.<br>Хэлтсийн “Дотоод ажил үүргийн хуваар”-ийн дагуу Замын-Үүд боомтод үүссэн хорио цээрийн хяналт шалгалттай холбоотой шийдвэрлэх асуудлын саналуудыг хүлээн авч хэлтсийн удирдлагуудад танилцуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.<br>Мэдээ, тайлан нэгтгэхтэй холбоотой үүссэн алдаа, дутагдлын талаар хэлтсийн дарга, чиглэлийн байцаагч нарт танилцуулж Газар, хороодын байцаагч нарт мэдээлэл өгч ажилласан.<br>“Мал эмнэлгийн хяналт, шалгалт цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”- сэдэвт багц сургалтын хилийн боомт дахь мал эмнэлгийн хяналт хариуцсан улсын байцаагчдад цахим хэлбэрээр зохион байгуулж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | улмаас буцаж ирсэн мах, махан бүтээгдэхүүнийг шалган шийдвэрлэх, БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдэд импортлогч орны хяналтын хуудсын дагуу холбогдох хяналт, шалгалт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт тус тус ажилласан. | -Харъяа гаалийн газар хороодын хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын үед илрүүлсэн зөрчил /саатуулсан , хураасан, устгасан, буцаасан, шийтгэвэр ногдуулсан гэх мэт/ -ийн мэдээг чиглэлийн хяналт бүрээр нэгтгэн, дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж, тайлагнана. | | | |
| 3 | Бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор лабораторийн шинжилгээнд хамруулсан үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдсан нийт бараанаас 75,6 тн, 8172 ширхэг барааг абораторийн шинжилгээнд 9298 удаагийн дээж авалтаар хамруулж, үүний 54852 үзүүлэлт шаардлага хангаж, 128 үзүүлэлт шаардлага хангаагүй. Улсын төсөвт шинжилгээний төлбөр болох 471 сая төгрөгийн оруулсан | - Гаалийн харьяа газар хороодын салбар лаборатори болон бусад итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамрагдсан бараа ( мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, гэх мэт) -ны мэдээг сар бүр авч, зөрөг гарсан сорьцонд дүн шинжилгээ хийн, удирдлагын мэдээллээр хангаж ажиллана. | 2024 онд Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр нийт 6207 аж ахуйн нэгж, 6 иргэн бараа экспортолсоноос 5875 мэдүүлгээр ангилалтын тоо хэмжээгээр 104,235,700 тн, 2 мэдүүлгээр 300 литр, 159 мэдүүлэгээр 276404 ширхэг, 207 мэдүүлэгээр 68447 толгой, 1 мэдүүлэгээр 1000дм2, 1 мэдүүлгээр 11 $м^3$ , 1 мэдүүлгээр 36 мян.ширхэг, 127 мэдүүлгээр 4,762,980,920 $дм^2$ бараа экспортлогдсон.<br>3004 аж ахуйн нэгж, 9 иргэн бараа импортолсоноос 3997 мэдүүлгээр ангилалтын тоо хэмжээгээр 36,661.8 тн, 31 мэдүүлгээр 40217 мян.литр, 244 мэдүүлэгээр 56,930,377 ширхэг, 178 мэдүүлгээр 3540 толгой, 25 мэдүүлгээр 9,938,444 тун, 3 мэдүүлэгээр 428,805 дм2, 4 мэдүүлэгээр 2,038,500 м2, 15 мэдүүлэгээр 2,177,9 мян.ширхэг бараа импортлогдсон байна. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| | | | ХХААХҮЯам болон Дэлхийн банк Олон Улсын санхүүгийн корпорацаас хамтран хэрэгжүүлж буй | -Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдсан зарим | МУ-аас 2024 оны 03 дугаар сард экспортлогдсон мах, махан бүтээгдэхүүний мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Бараа, тээврийн хэрэгслийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтын мэдээ, мэдээллийг гаргаж холбогдох байгууллага, удирдлагыг мэдээллээр хангах, ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Мал эмнэлгийн хорио цээрийн дэглэм бүхий эрүүл бүс, хамгаалалттай аж ахуй байгуулах “Эрүүл бүс, хамгаалалттай аж ахуйн эрх зүйн орчныг бүрдүүлэх” төсөлд хорио цээрийн байгууллагыг төлөөлөн ажилласан.<br>ХХААХҮЯ-ны дэд сайдаар ахлуулсан мах, махан бүтээгдэхүүний экспортыг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдах, экспортын баримт бичиг бүрдүүлэх цаг хугацааг багасгах зорилго бүхий “Цахим нэг цонх”- төслийн ажлын хэсэгт ажиллан 3 удаагын уулзалт, хуралд оролцож Хорио цээрийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, хяналт шалгалтын талаар мэдээллүүдийг өгч хамтран ажиллаж байна.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр баталсан "Нийслэл, орон нутгийн зарим гаалийн газар, хороодын үйл ажиллагаатай танилцаж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж" -аар хийгдэх ажлын хэсэгт Гаалийн хорио цээрийн хэлтсээс орж ажиллан Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хорио | барааны мэдээг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох төрийн захиргааны байгууллага, дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллана.<br>- Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааны техникийн зохицуулалт, стандарт, журам, дүрэм боловсруулах, бодлого төлөвлөлт, эрх зүйн зохицуулах, худалдааг хөнгөвчлөх, экспортын дэмжих, цахимжуулалт, боомтын хөгжил зэрэг асуудлаар холбогдох төрийн захиргааны болон дээд шатны байгууллагаас томилсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллана. | хийн байгууллагын удирдлагуудыг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.<br>Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 08 дугаар тушаалаар Улсын онцгой комиссын “Шуурхай штабт” гаалийн байгууллагыг төлөөлөн ажилласан:<br>Ажиллах хугацаанд Улсын хилээр нэвтэрсэн “Малын тэжээл, тэжээлийн нэмэлтийн мэдээ, мэдээлэл, Зээл, тусламжийн барааг гаалийн хилээр нэвтрүүлэх үед түргэвчилсэн журмаар шийдвэрлэх зэрэг ажлуудын төлөвлөгөөг боловсруулж ажилласан.<br>Штабын удирдлагуудаас өгөгдсөн бусад ажил, үүргүүдийг цаг тухай бүрт нь биелүүлж ажилласан.<br>Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн “Цахим нэг цонх” той холбоотой гадаад зөвлөхөөс зохион байгуулсан сургалтад хамрагдсан.<br>Дэлхийн худалдааны байгууллага болон Олон Улсын худалдааны төвөөс зохион байгуулсан Уул уурхайн бус Үндэсний экспортын бүрэлдэхүүн хэсэг болох МУ-ын Мах, махан бүтээгдэхүүний экспортын стратеги 2024-2028 баримт бичиг боловсруулах ажлийн хэсэгт ажиллан санал өгч ажилласан.<br>БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Эрээн хотод 2024 оны 06 дугаар сарын 26-27 ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Монгол, Орос, Хятад гурван улсын экспорт, импорт, худалдааны эргэлт, транзит тээврийг нэмэгдүүлэх"- ээлжит хуралд оролцхоор Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдон уулзалтад оролцсон.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын дарга Жи Юнчян тэргүүтэй | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цээрийн албаны үйл ажиллгааг шалган, зааварчлан үнэлэлт дүгнэлт өгч цаашид авч хэрэгжүүлэн албан даалгаварт саналаа хүргүүлэн ажилласан. | | төлөөлөгчид 2024 оны 11 дүгээр сарын 28-29-ны өдрүүдэд МУ-д айлчлах бөгөөд Улаанбаатар хотноо ажиллаж, хил орчмын аялал жуулчлал, боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа зэрэг тодорхой асуудлаар холбогдох яамдын төлөөлөлтэй уулзаж, санал солилцох уулзалтад оролцсон. | | |
| 5 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Мэдээллийн технологийн газарт гаалийн хорио цээрийн чиглэлийн газар, хороодын хяналт, шалгалтын тайлан, лабораторийн тайлан, хорио цээрийн ГУБ тайланг Гаалийн автоматжуулсан удирдлагын системээр нэгтгэдэг болгох, одоо байгаа тайланд нэмэлт өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлж, хорио цээрийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, гаалийн хяналт, шалгалтын эрсдэлийн шалгуур, программтай уялдуулах талаар ажиллаж байна.<br><br>Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйн биржээс хэрэгжүүлж буй цахим нэг цонхны сиситем /export.mofa.gov.mn/-д | -Гаалийн эрсдэлийн нэгдсэн удирдлагын журмыг ЭУХ-тэй хамтран боловсруулж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгож, хэрэгжүүлнэ.<br>-Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгоно.<br>-Экспортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл зэрэг баталгаажуулалтын баримт бичгийн олголт Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжиж буйтай холбогдон бэлтгэл ажлыг хангах, шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ. | Тайлант хугацаанд /Caps.gaali.mn/ цахим системээр импортын мэдэгдэл, экспортын гэрчилгээ хүссэн давхардсан тоогоор 790 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.<br>Edoc.ecustoms.mn цахим системээр 97 албан хүсэлтийг хүлээн авч 100 хувь шийдвэрлэсэн. Үүнээс албан бичгээр хариу хүргүүлсэн 17, хугацаа хоцроосон албан бичиг байхгүй болно.<br>Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хорио цээрийн хэлтсийн хэрэгжүүлж байсан чиг үүргийг шилжүүлэх ажлийн хэсгийн уулзалтад оролцож тодорхой саналуудыг гаргасан.<br>Мөн МЭЕГ-ын ажил хүлээлцэх ажлийн төлөвлөгөөнд санал хүргүүлж ажилласан.<br>Аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын "CPV Food" Co.,Ltd, Бүгд Найрамдах Солонгос Улсын " Harim" Co.,Ltd компануудын тахианы мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үйл ажиллагаанд импортлохын өмнөх эрсдэлийн хянан магадлагааг хийж ажилласан.<br>1281 болон хэлтсийн дотоод утсаар холбогдсон иргэн, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл хүссэн хүсэлтэд тодорхой мэдээллүүдийг түргэн шуурхай өгч ажилласан.<br>"Бараанаас сорьц, дээж, загвар авах, | 2024.01.01<br>2024.12.10 | 97 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаалийн хорио цээрийн apqs.gaali.mn системийг холбож ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багасгасан.<br>Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Олон Улсын Санхүүгийн корпорацын зөвлөх үйлчилгээ "Монгол мах" төсөлтэй хамтран Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх сунгуулах, шинээр бүртгүүлэх хүсэлтэй 80 гаруй махны үйлдвэрийн 116 төлөөлөлд "Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох хүсэлт гаргах, хяналтын хуудас боловсруулах" сэдэвт сургалтыг зохион байгуулж ажилласан. | -Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлээр гадаад худалдаанд оролцогч аж ахуйн нэгжүүдэд зориулсан мэдээ мэдээллийг боловсруулж, веб сайтад байршуулж, цаг үеийн шаардлагатай мэдээ мэдээллийг ил тод, нээлттэй, цаг алдалгүй мэдээлж, ажиллах, сургалт зохион байгуулна.<br>-Экспортлогч улсын үйлдвэрүүдэд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хорио цээрийн эрсдэлийн хянан магадлагаа хийнэ. | магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-ын 3 заалтад санал өгсөн.<br>ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар болон МЭЕГ-ын хамтарсан мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн импортлохын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт ажилласан.<br>Дээрх ажлын хэсэг нь ОХУ-аас экспортлох хүсэлт гаргасан 22 аж ахуйн нэгж БНХАУ-аас хүнсний өндөг импортлох хүсэлт гаргасан 4 ААН, Франц улсаас үржлийн үхэр импортлох хүсэлт гаргасан 1 ААН-ийн хүсэлтийг тус тус хянан танилцуулга боловсруулж холбогдох нэгжийн даргаар хянуулж ХХААХҮ-ийн сайдад танилцуулж шийдвэрлүүлсэн. | | |
| | | | Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр баталсан А/62 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаал гарсаны дагуу "Эрсдэлийн удирдлагын модуль /CAIS CIMS/, Хорио цээрийн модуль /CAIS CIMS/, Зөрчлийн удирдлагын модуль, Тайлан мэдээний хэрэгсэл /CAIS эсвэл | "Алсын хараа 2050" урт болон дунд хугацааны, Засгийн газрын 2021-2024 оны хөтөлбөр, Гаалийн байгууллагын стратегийн зорилтод хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой зорилтын биелэлтийг | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйн биржээс хэрэгжүүлж буй цахим нэг цонхны сиситем /export.mofa.gov.mn/-д гаалийн хорио цээрийн apqs.gaali.mn системийг холбож ААН-ийн экспортод зарцуулах цаг, хугацааг багасгасан.<br>Дээрх системийн үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн болон сайжруулж хөгжүүлэх асуудлуудаар төрийн болон бусад байгууллагуудтай хамтарч ажилласан.<br>Хорио цээрийн гэрчилгээ, мэдэгдэл | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Tableau/,Лабораторийн удирдлага модуль -CAIS, CIMS, www.gaali.mn, Төлбөрийн модуль зэрэг ажлуудыг дэс дараалалтай төлөвлөн "Интерактив" ХХК-тай хамтран ажиллаж байна. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд импортлохын өмнөх эрсдэлийн задлан шинжилгээ, хянан магадлагаа, хийх журмын төслийг боловсруулж дуусгасан. Хэлтсийн удирдлагаас өгөгдсөн үүргийн дагуу УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд боловсруулан тайлагнаж ажилласан. | чиглэлийн хяналт бүрээр хэрэгжүүлж ажиллана.<br><br>-Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай барааны мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн болон протоколуудад санал өгч холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах<br><br>-Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хийх албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлнэ. | олгох цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийх шаардлагуудын талаар 6 ажлын санал боловсруулж Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.<br><br>Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх шинээр бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 5 аж ахуйн нэгжийн баримт, материалд хяналт, шалгалт хийж баталгаажуулан ХХААХҮЯ-нд уламжилсан.<br><br>Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хорио цээрийн хэлтсийн мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулж ажлийн хэсэгт хүргүүлсэн. | | |
| 7 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг боловсронгуй болгох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журамын төсөлд санал өгч ажилласан.<br>Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/25 тоот "Маягтын загвар нэмэлтээр батлах тухай" тушаалаар "Евразийн эдийн засгийн холбооны нутаг дэвсгэрт экспортлох мал, амьтан, тэдгээрийн | -ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэх саналыг боловсруулж, холбогдох газар, хэлтэст хүргүүлнэ. | "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-д санал өгч ажилласан.<br>Хэлтсийн удирдлагаас өгөгдсөн үүргийн дагуу УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд боловсруулан тайлагнаж ажилласан.<br>"Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал хэлэлцүүлэг"-т 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр оролцож "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хууль"-ийн төслийн танилцуулгад санал өгч ажилласан.<br>МУ-ын ЗГ-ын хуралдаанаас хуулийн | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний 10 төрлийн гэрчилгээний загварыг батлуулсан. Гаалийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд хорио цээрийн хяналтын талаарх холбогдох саналуудыг өгч ажилласан. “Экспорт, импортын зөвшөөрөл олгох, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын мэдээллийг цахимжуулах-гарц, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулахад хамтран оролцож төрийн эрх бүхий байгууллагуудад албан бичиг хүргүүлж санал солилцон ажилласан. | -Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой хуулиудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийн мэдээг Хуулийн хэлтэст хүргүүлэн, холбогдох байгууллагатай ажлын уялдааг хангана. | давхардал, хийдэл зөрчлийг арилгах зорилгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 850 гаруй хуулинд дүн шинжилгээ хийх үүрэг даалгавар өгсний дагуу Гаалийн хорио цээрийн хяналт шалгалтад ашиглагдаж буй хууль тогтоомжуудын давхардал, хийдэл, зөрчлийн саналыг чиглэл бүрээс гаргуулан авч нэгтгэн хуулийн хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлсэн. “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тавих тусгай шаардлага, тээвэрлэлтийн өмнөх тээврийн хэрэгслийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн журам”-ын төсөлд санал өгч, боловсруулж ажилласан. | | |
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Удирдлагын шуурхай хуралдаанаас өгсөн 3 үүрэг даалгавар, 1 зөвлөмж, онлайн хурлын 1 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан. | Газрын удирдлагууд, зөвлөгөөн, шуурхай хуралдаан, мэргэжлийн болон захиргааны зөвлөлийн хуралдаан, удирдах дээд байгууллагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгавар болон бусад хугацаатай өгөгдсөн албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийг хангах. | Байгууллагын удирдлагууд болон хэлтсийн дарга, ахлах байцаагчаас өгөгдсөн үүрэг, даалгавруудыг цаг тухай бүрт нь биелүүлж тайлагнаж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| 9 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хийж гүйцэтгэсэн байна. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх | Монголын Биотехнологийн нийгэмлэгээс зохион байгуулж буй "Био аюулгүйн зуучлагч механизмыг үр дүнтэй ашиглах нь" сэдэвт сургалтад хамрагдсан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ажлын цаг ашиглалтыг 100 хувь ханган ажилласан. | Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. | Жилийн эцсийн байдлаар тасалсан өдөргүй бүтээмжтэй ажилласан.<br>Ажлийн 14 хоног эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| ХОЁР.“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ТЖАХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг ханган ажилласан. | 1.ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг ханган ажилласан байна. | ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын болон нэгжийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |
| 2 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажилласан | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажилласан байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу 2023 онд үйлдсэн баримт, бичгүүдийг архивын нэгж үүсгэн хүлээлгэж өгсөн.<br><br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2023 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж мэдүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.10 | 100 |

## ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| НЭГ."ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1 | Арга хэмжээ<br>Монгол бичгийн чадвараа дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Монгол бичгээр унших, бичих чадвар сайжирсан байна. | Бие даан судлаж байна. Унших чадвар дээшилсэн. | 2024.01.01<br>2024.12.10 | 95 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ | Г.ШҮРЭНЧУЛУУН /.........................................../ | 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

1554

*Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Г.ШҮРЭНЧУЛУУНЫ 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

(Гүйцэтгэх албан тушаалтан)

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Нэгжийн нэр: ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТЭС

## 1. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Зорилт 1. **Зорилт 1. “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ №1.2. Бараа тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт | 55 | 10 | 65 | |
| 3 | Арга хэмжээ №1.3. Бараанд хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор лабораторийн шинжилгээнд хамруулсан үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх | 50 | 10 | 60 | |
| 4 | Арга хэмжээ №1.4. Бараа, тээврийн хэрэгслийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын хяналтын мэдээ, мэдээллийг гаргаж холбогдох байгууллага, удирдлагыг мэдээллээр хангах, ажлын хэсэгт ажиллах | 60 | 10 | 70 | |
| 5 | Арга хэмжээ №1.5. Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | 55 | 10 | 65 | |
| 6 | Арга хэмжээ №1.6. Бодлогын баримт бичгийн | 55 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зорилт, арга хэмжээний хэрэгжилт | | | | |
| 7 | Арга хэмжээ №1.7.<br>Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг боловсронгуй болгох | 50 | 8 | 58 | |
| 8 | Арга хэмжээ №1.8.<br>Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 10 | 70 | |
| 9 | Арга хэмжээ №1.9.<br>Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх | | | | |
| 10 | Арга хэмжээ №1.10.<br>Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| Зорилт 2. **.“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1 | Арга хэмжээ 2.1<br>ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ №2.2.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | 60 | 10 | 70 | |
| Нэмэлт үүрэг даалгаварын биелэлт | | | | | |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Монгол бичгийн чадвараа дээшлүүлэх | 100 | 15 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 1. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 2. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 3 | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хамт олны үнэлгээ (0-8 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн огноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт | 65 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ) | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ) | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 5 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих) | ( 94 оноо ) |
| Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо, + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 94 |

**ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:**
ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........................................ (Г.БАТМӨНХ)
(Гарын үсэг) (огноо: 2024.06.10

**ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:**

МАЛ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТ ХАРИУСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ........................................ (Г.ШҮРЭНЧУЛУУН)
(Гарын үсэг) (огноо: 2024.06.10)

**ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:**

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙГ ТӨЛӨӨЛЖ АХЛАГЧ ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

............................................ (Г.ЭНХТАЙВАН)

(Гарын үсэг) ........2024.07.26.

(огноо: )

**ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:**
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

............................................ ( Ж.БАЯСГАЛАН )

(Гарын үсэг) (огноо: )

**ҮНЭЛГЭЭГ БАТАЛГААЖУУЛСАН:**
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

............................................ (Р.ОТГОНЖАРГАЛ)

(Гарын үсэг) (огноо: )